



**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ТОГТООЛ**

2008 оны 03 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

**ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
33 ДУГААР ЗҮЙЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ**

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлийн зарим заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Гамшгаас хамгаалах тухай хууль /цаашид хуулийн гэх/ -ийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасан **“Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагч ...”** гэдэгт онцгой байдлын асуудал эрхэлсэн төв, орон нутгийн байгууллагад ажиллаж байгаа төрийн тусгай болон үйлчилгээний нийт албан хаагчид хамаарна.

2. Мөн зүйлийн 33.7-д заасан **“Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын тусгай албан тушаал эрхэлдэг албан хаагч ...”** гэдэгт хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3, 32 дугаар зүйлд заасны дагуу тангараг өргөж, ажил, мэргэжлийн онцлогт тохирсон цол, дүрэмт хувцас хэрэглэдэг, онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтныг хамааруулан ойлгоно.

3. Мөн зүйлийн 33.12-т заасан **“Аврах ажиллагаанд оролцдог албан хаагч ...”** гэдгийг онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын тусгай албан тушаал эрхэлдэг албан хаагч гэж ойлгох бөгөөд тэдгээрт хуулийн 33 дугаар зүйлийн 33.12.2, 33.12.3, 33.12.4, 33.12.5, 33.12.6-д заасан нэмэлт хөнгөлөлтийг эдлүүлнэ.

Харин тэдгээрээс аврах ажиллагаа явуулсан тохиолдолд хуулийн 33 дугаар зүйлийн 33.12.1-д заасан урамшууллыг холбогдох байгууллагаас гаргасан журамд зааснаар олгоно.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР

ШҮҮГЧ

П.ЦЭЦГЭЭ